“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 дугаар сарын 14-ний өдөр № 26/41 Улаанбаатар хот

2026 оны санхүүгийн тайланд
хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн АХ-26/14 тоот дүгнэлт болон 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар Компанийн 2026 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгосон боловч тус компани нь зохицуулагч байгууллагын Монгол Улсын Аудитын тухай хуулийн хэрэгжилт, зарчмыг хэрэгжүүлэх байр суурь өөрчлөгдсөнтэй холбогдуулан Компанийн 2026 оны нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийхээс албан ёсоор татгалзсан болохыг дурдсугай.

2. Компанийн 2026 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-ийг шинээр сонгосугай.

3. “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

4. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Компанийн ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 26/28 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 дугаар сарын 14-ний өдөр № 26/42 Улаанбаатар хот

Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тус эрэлтийг хангах, эх үүсвэрийн удирдлагын үр ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Вестернкредит ББСБ” ХХК-аас энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн хүрээнд зээл авахаар шийдвэрлэсүгэй.

2. “Вестернкредит ББСБ” ХХК-тай энэхүү тогтоолын Хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

3. “Вестернкредит ББСБ” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, зээл ашиглалт болон холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ⁂1118267206

ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 дугаар сарын 14-ний өдөр № 26/43 Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн АХ-26/15 тоот дүгнэлт болон 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн үйл ажиллагааны эрэлтийг хангах, үйл ажиллагааны цаашдын өсөлтийг хадгалах, шаардлагатай үед эх үүсвэрийг тухай бүр авч ашиглах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр толгой компани “АНД Системс” ХХК-тай “Санхүүжилтийн гэрээ”-г байгуулж, 20,000,000,000 (хорин тэрбум) хүртэл төгрөгийн болон 3,000,000 (гурван сая) хүртэл ам.долларын зээлийн шугамыг ашиглаж буйг дурдсугай.

2. Компанийн зүгээс тус “Санхүүжилтийн гэрээ”-ний хугацааг дахин 1 (нэг) жилээр, ижил нөхцөлөөр сунгах нь Компанийн үйл ажиллагааны өсөлтийг хадгалах, харилцагчдын эрэлтийг хангахад ач холбогдолтой байх тул “Санхүүжилтийн гэрээ”-ний хугацааг сунгаж, нэмэлт гэрээ байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.

3. “Санхүүжилтийн гэрээ”-ний хугацааг сунгаж, нэмэлт гэрээ байгуулах, түүнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

_____ Ц.ТҮМЭНЦОГТ _____ Х.БАТСҮРЭН

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ⫫1118267206

_____ С.НЭРГҮЙ _____ С.ЭНХ-АМГАЛАН